

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-5

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/ 3-5

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
04 дүгээр сарын 30-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 56 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Б.Мөнхсоёл, О.Цогтгэрэл;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Х.Баттулга;
Тасалсан: М.Бадамсүрэн, Э.Батшугар, Х.Ганхуяг, Б.Жаргалан,
Ч.Лодойсамбуу, М.Мандхай, П.Сайнзориг, С.Цэнгүүн.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд үг хэлэв.

Р.Сэддорж: “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 06 минут үргэлжилж, 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
15 цаг 56 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батболд, Батнайрамдал, Батсүмбэрэл, Батчимэг, Бямбасүрэн, Ганбаатар, Лувсанжамц, Найдалаа, Соронзонболд, Сэддорж, Ундраа, Энхтүвшин, Энхцэцэг нарын гишүүд ирсэн байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52 хувьтай бүрэлдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 4 сарын 30-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Ирцийг танилцуулж дууссан. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал 1.“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл, Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хянан шалгах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамж.

Хэлэлцэх асуудалтай холбогдолтой саналтай гишүүд байна уу? Асуулт, саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байхгүй учраас хэлэлцэх асуудалдаа орьё.

Хэлэлцэх асуудал 1.“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Удирдамжийг гишүүд уншиж байгаа байх.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол “Ажлын хэсгийн удирдамж, үйл ажиллагааны удирдамж батлах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.“Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж хэлэлцүүлэх.

Тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

Намрын гэдэг нь хаврынх уу тээ? Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Харин бид хэд дотроо ярилцаад ямар ч байсан 6 сарын 15 хүртэл ажиллая л гэж бодож байгаа юм төлөвлөгөөгөөрөө. Харин тэгэхээр 6 сарын 15 гэхэд хаврынхад амжих уу тэгвэл? Тэгвэл хаврынх гэвэл яасан юм л гэсэн саналтай байна.

Р.Сэддорж: 2 дахь заалтыг дахиж уншъя. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж хэлэлцүүлэх.

Тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг ажлын хэсгийн дарга Соронзонболдод үүрэг болгосугай гэсэн ийм Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд танилцууллаа.

Та бүхэн удирдамжтай танилцаж байгаа байх. Урьдчилж өгсөн байх.

Ажлын хэсгийн удирдамж болон тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Алга байна. Гишүүд, шууд явчих уу тээ? Санал хураалт явуулна. Удирдамжтайгаа танилцсан уу? Энэ дээр бас ганц, нэг Улсын Их Хурлын гишүүд нэмж оръё гэсэн хүсэлт өгч байна. Тэгээд энийг ажлын хэсгийн дарга хүлээж аваад дараагийн хурал дээр санал хураалтаар шийдэх шаардлагатай байгаа.

Санал хураалт явуулж эхэлье. “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж байна. Хуралдаан үүгээр өндөрлөснийг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

16.02 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР